



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

# **ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ**

**2025 оны 4 дүгээр сар**

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ  
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН  
СУДАЛГАА, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2025 оны 05 сарын 14  
Улаанбаатар хот

# НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

## Үзүүлэлт

## Тодорхойлолт\*

|                  |                                                                                                                                                                                                                                                                                                     |
|------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Тээсэн ачаа      | Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ. |
| Ачаа эргэлт      | Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.                                                                                      |
| Тээсэн зорчигч   | Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.                                                                                                                                                                                                                            |
| Зорчигч эргэлт   | Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.                                                                                                                                                                                  |
| Шилжүүлсэн тн.км | Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.                                                                                |
| Тээврийн орлого  | Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.                                       |

\*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

### ТАНИЛЦСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

### ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

Г.БАТБАЯР

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.МЯДАГМАА

### БОЛОВСРУУЛСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ц.НЭМЭХЖАРГАЛ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗААЯ

Энэхүү эмхэтгэлийг ҮСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ<sup>1</sup> бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

<sup>1</sup> Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

**АГУУЛГА**

|                                                                                 |           |
|---------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ .....</b>       | <b>5</b>  |
| 1.1. АЧАА ТЭЭВЭР .....                                                          | 6         |
| 1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР .....                                                       | 7         |
| <b>БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР .....</b>                                       | <b>8</b>  |
| 2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА .....                                                    | 8         |
| 2.1.1. АВТОТЭЭВРИЙН ЭКСПОРТЫН АЧАА, БООМТУУДААР.....                            | 9         |
| 2.1.2. АВТОТЭЭВРИЙН ИМПОРТЫН АЧАА, БООМТУУДААР.....                             | 10        |
| 2.1.3. АВТОТЭЭВРИЙН АЧААНЫ НЭР ТӨРӨЛ.....                                       | 11        |
| 2.1.4. АВТОТЭЭВРИЙН АЧАА ЭРГЭЛТ, БООМТУУДААР.....                               | 12        |
| 2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ .....                                                 | 12        |
| 2.3. АВТО ЗАМЫН БООМТУУДААР НЭВТЭРСЭН АЧААТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ ..... | 14        |
| <b>БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР .....</b>                                        | <b>15</b> |
| 3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА .....                                                     | 15        |
| 3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ .....                                                  | 18        |
| <b>БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР .....</b>                                   | <b>19</b> |
| 4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА .....                                                 | 19        |
| 4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ .....                                             | 20        |
| 4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ .....                                | 21        |
| 4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ .....                              | 22        |
| 4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ.....                                                      | 23        |

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

|                                                                                   |    |
|-----------------------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....               | 5  |
| Хүснэгт 2. Автотээврийн ачаа тээвэр.....                                          | 8  |
| Хүснэгт 3. Автотээврийн экспортын ачаа, боомтуудаар.....                          | 9  |
| Хүснэгт 4. Автотээврийн импортын ачаа, боомтуудаар.....                           | 10 |
| Хүснэгт 5. Автотээврийн ачааны нэр төрөл.....                                     | 11 |
| Хүснэгт 6. Автотээврийн ачаа эргэлт.....                                          | 12 |
| Хүснэгт 7. Автотээврийн зорчигч.....                                              | 12 |
| Хүснэгт 8. Хот хоорондын нийтийн тээврийн зорчигч.....                            | 13 |
| Хүснэгт 9. Авто замын боомтуудаар гарсан ачаатай тээврийн хэрэгслийн бүртгэл..... | 14 |
| Хүснэгт 10. Төмөр замын ачаа тээвэр.....                                          | 15 |
| Хүснэгт 11. Төмөр замын зорчигч тээвэр.....                                       | 18 |
| Хүснэгт 12. Агаарын тээврийн ачаа.....                                            | 19 |
| Хүснэгт 13. Агаарын тээврийн зорчигч.....                                         | 20 |
| Хүснэгт 14. Агаарын тээврийн олон улсын зорчигч.....                              | 21 |
| Хүснэгт 15. Агаарын тээврийн орон нутгийн зорчигч.....                            | 22 |
| Хүснэгт 16. Нислэг гүйцэтгэл.....                                                 | 23 |

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

|                                                                                      |    |
|--------------------------------------------------------------------------------------|----|
| Зураг 1. Нийт ачаа тээвэр.....                                                       | 6  |
| Зураг 2. Нийт экспорт.....                                                           | 6  |
| Зураг 3. Нийт импорт.....                                                            | 6  |
| Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....                                                    | 7  |
| Зураг 5. Олон улсад зорчигч.....                                                     | 7  |
| Зураг 6. Орон нутагт зорчигч.....                                                    | 7  |
| Зураг 7. Автотээврээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар.....                            | 8  |
| Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....                       | 8  |
| Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн, боомтоор.....                            | 9  |
| Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор.....                            | 10 |
| Зураг 11. Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар.....                              | 11 |
| Зураг 12. Экспортын нүүрсний хэмжээ, тонн, сараар.....                               | 11 |
| Зураг 13. Автотээврийн зорчигч.....                                                  | 12 |
| Зураг 14. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл.....                                    | 14 |
| Зураг 15. Төмөр замын ачаа .....                                                     | 15 |
| Зураг 16. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....                          | 16 |
| Зураг 17. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....                                       | 16 |
| Зураг 18. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....                             | 16 |
| Зураг 19. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар.....             | 16 |
| Зураг 20. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2025.03.31..... | 17 |
| Зураг 21. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....                     | 17 |
| Зураг 22. Төмөр замын зорчигч тээвэр.....                                            | 18 |
| Зураг 23. Төмөр замын зорчигч, хоногоор.....                                         | 18 |
| Зураг 24. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....                                | 19 |
| Зураг 25. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....                                   | 19 |
| Зураг 26. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....                                | 19 |
| Зураг 27. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....                               | 20 |
| Зураг 28. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....                               | 20 |
| Зураг 29. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....                                  | 21 |
| Зураг 30. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....     | 22 |
| Зураг 31. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....                                       | 22 |
| Зураг 32. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....   | 23 |
| Зураг 33. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....                                     | 23 |

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ<sup>2</sup>

Хүснэгт 1



| №  | Үзүүлэлт                                                | Тээврийн төрөл                       | Хэмжих нэгж | 2024 он  |           | 2025 он  |           | Өсөлт бууралтын % /өссөн дүн/ |
|----|---------------------------------------------------------|--------------------------------------|-------------|----------|-----------|----------|-----------|-------------------------------|
|    |                                                         |                                      |             | 4-р сар  | Өссөн дүн | 4-р сар  | Өссөн дүн |                               |
| 1  | Тээвэрлэсэн ачаа                                        | Автотээвэр                           | мян.тн      | 7,219.5  | 25,165.2  | 7,828.6  | 26,549.3  | 5.5%                          |
|    |                                                         | Төмөр зам                            | мян.тн      | 3,661.9  | 14,562.1  | 3,295.7  | 13,597.2  | -6.6%                         |
|    |                                                         | Агаарын тээвэр                       | мян.тн      | 0.8      | 2.9       | 0.9      | 2.9       | -0.5%                         |
|    |                                                         | Нийт ачаа                            | мян.тн      | 10,882.1 | 39,730.3  | 11,125.3 | 40,149.4  | 1.1%                          |
| 2  | Дамжин өнгөрөх ачаа /транзит/                           | Төмөр зам                            | мян.тн      | 413.8    | 1,687.0   | 499.1    | 1,889.0   | 12.0%                         |
| 3  | Ачаа гаргалт /экспорт/                                  | Төмөр зам                            | мян.тн      | 921.0    | 3,662.7   | 844.3    | 3,617.4   | -1.2%                         |
|    |                                                         | Автотээвэр                           | мян.тн      | 6,951.0  | 24,414.2  | 7,498.7  | 25,672.6  | 5.2%                          |
|    |                                                         | Нийт                                 | мян.тн      | 7,872.0  | 28,076.9  | 8,343.0  | 29,290.0  | 4.3%                          |
| 4  | Ачаа оруулалт /импорт/                                  | Төмөр зам                            | мян.тн      | 304.9    | 1,314.9   | 279.6    | 1,166.7   | -11.3%                        |
|    |                                                         | Автотээвэр                           | мян.тн      | 268.5    | 751.0     | 330.0    | 876.7     | 16.7%                         |
|    |                                                         | Нийт                                 | мян.тн      | 573.4    | 2,065.9   | 609.6    | 2,043.4   | -1.1%                         |
| 5  | Дотоодод тээвэрлэсэн ачаа                               | Төмөр зам                            | мян.тн      | 2,022.1  | 7,897.5   | 1,672.7  | 6,924.1   | -12.3%                        |
|    |                                                         | Агаарын тээвэр                       | мян.тн      | 0.8      | 2.9       | 0.9      | 2.9       | -0.5%                         |
|    |                                                         | Нийт                                 | мян.тн      | 2,022.8  | 7,900.5   | 1,673.6  | 6,927.0   | -12.3%                        |
| 6  | Ачаа эргэлт                                             | Автотээвэр                           | сая тн.км   | 1,084.1  | 3,993.4   | 1,090.9  | 4,060.1   | 1.7%                          |
|    |                                                         | Төмөр зам                            | сая тн.км   | 1,772.5  | 7,021.9   | 1,716.5  | 6,918.3   | -1.5%                         |
|    |                                                         | Агаарын тээвэр                       | сая.тн.км   | 2.5      | 9.8       | 2.0      | 7.7       | -21.6%                        |
|    |                                                         | Нийт                                 | сая тн.км   | 2,859.1  | 11,025.1  | 2,809.4  | 10,986.1  | -0.4%                         |
| 7  | Зорчигчдын тоо                                          | Автотээвэр                           | мян.хүн     | 13,910.2 | 47,793.6  | 13,820.7 | 50,470.0  | 5.6%                          |
|    |                                                         | Төмөр зам                            | мян.хүн     | 165.2    | 600.5     | 144.9    | 544.1     | -9.4%                         |
|    |                                                         | Агаарын тээвэр                       | мян.хүн     | 138.5    | 550.5     | 157.2    | 636.6     | 15.6%                         |
|    |                                                         | Нийт зорчигч                         | мян.хүн     | 14,214.0 | 48,944.5  | 14,122.8 | 51,650.7  | 5.5%                          |
| 8  | Олон улсад зорчигчдын тоо                               | Автотээвэр                           | мян.хүн     | 48.1     | 208.3     | 51.3     | 167.6     | -19.5%                        |
|    |                                                         | Төмөр зам                            | мян.хүн     | 1.9      | 7.5       | 2.7      | 9.9       | 31.2%                         |
|    |                                                         | Агаарын тээвэр                       | мян.хүн     | 105.0    | 419.9     | 122.8    | 503.6     | 20.0%                         |
|    |                                                         | Нийт                                 | мян.хүн     | 155.1    | 635.7     | 176.8    | 681.1     | 7.1%                          |
| 9  | Орон нутагт зорчигчдын тоо                              | Автотээвэр                           | мян.хүн     | 112.5    | 469.9     | 126.4    | 503.7     | 7.2%                          |
|    |                                                         | Төмөр зам                            | мян.хүн     | 163.4    | 592.9     | 142.2    | 534.3     | -9.9%                         |
|    |                                                         | Агаарын тээвэр                       | мян.хүн     | 33.5     | 130.6     | 34.4     | 132.9     | 1.8%                          |
|    |                                                         | Нийт                                 | мян.хүн     | 309.3    | 1,193.5   | 302.9    | 1,170.9   | -1.9%                         |
| 10 | Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо             | Автотээвэр                           | мян.хүн     | 13,749.6 | 47,115.3  | 13,643.1 | 49,797.3  | 5.7%                          |
| 11 | Зорчигч эргэлт                                          | Автотээвэр                           | сая хүн.км  | 184.1    | 696.5     | 139.5    | 680.7     | -2.3%                         |
|    |                                                         | Төмөр зам                            | сая хүн.км  | 67.9     | 240.5     | 62.7     | 230.1     | -4.3%                         |
|    |                                                         | Агаарын тээвэр                       | сая хүн.км  | 290.9    | 1,299.4   | 334.8    | 1,596.3   | 22.8%                         |
|    |                                                         | Нийт                                 | сая хүн.км  | 542.9    | 2,236.4   | 537.0    | 2,507.1   | 12.1%                         |
| 12 | Агаарын тээврийн нислэгийн тоо                          | Олон улсын хөөрөлт, буултын тоо      | ш           | 850.0    | 3,282.0   | 943      | 3,743     | 14.0%                         |
|    |                                                         | Орон нутгийн хөөрөлт, буултын тоо    | ш           | 640.0    | 2,424.0   | 822      | 2,876     | 18.6%                         |
|    |                                                         | Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо | ш           | 5,225.0  | 19,997.0  | 6,250    | 24,501    | 22.5%                         |
| 13 | Авто замын боомтуудаар гарсан ачаатай тээврийн хэрэгсэл | ш                                    |             | 64,080.0 | 232,911.0 | 66,761.0 | 236,243.0 | 1.4%                          |
| 14 | Авто замын боомтуудаар орсон ачаатай тээврийн хэрэгсэл  | ш                                    |             | 11,168.0 | 32,054.0  | 17,367.0 | 46,442.0  | 44.9%                         |

<sup>2</sup> Зам, тээврийн салбарын 2025 оны 4 дүгээр сарын статистикийн мэдээг 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдөр гаргав.

## 1.1. АЧАА ТЭЭВЭР

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2025 оны 4 дүгээр сард 11.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 4 дүгээр сартай харьцуулахад 2.2%-аар өссөн байна. Харин 2025 оны өссөн дүнгээр буюу эхний 4 сард нийт 40.1 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 1.1%-аар өссөн байна.


- Автотээврээр 2025 оны 4 дүгээр сард 7.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 4 дүгээр сартай харьцуулахад 8.4%-аар өссөн байна. 2025 оны өссөн дүнгээр нийт 26.5 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 5.5%-аар, экспортын ачаа 25.7 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 5.2%-аар, импортын ачаа 876.7 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 16.7%-аар тус тус өссөн байна.
- Төмөр замын тээврээр 2025 оны 4 дүгээр сард 3.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 4 дүгээр сартай харьцуулахад 10%-аар буурлаа. Нийт өссөн дүнгээр 13.6 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.6%-аар, дотоодын ачаа 6.9 сая тонн болж 12.3%-аар, экспортын ачаа 3.6 сая тонн 1.2%-аар, импортын ачаа 1.2 сая тонн болж 11.3%-аар тус тус буурсан бол дамжин өнгөрсөн ачаа 1.9 сая тонн болж 12%-аар өссөн байна.
- Агаарын тээврээр 2025 оны 4 дүгээр сард 904.3 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны 4 дүгээр сартай харьцуулахад 19.8%-аар өссөн. 2025 оны эхний 4 сарын байдлаар 2,930.3 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 0.5%-аар буурсан байна. Үүнээс ачаа 2,864 тонн тээвэрлэсэн нь 0.2%-аар, шуудан 66.3 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 14.9%-аар тус тус буурсан байна.



Экспортоор 4 дүгээр сард 8.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 4 дүгээр сартай харьцуулахад 6%-аар өссөн байна. Харин 2025 оны өссөн дүнгээр экспортын хэмжээ 29.3 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 4.3%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 3.6 сая тонн тээвэрлэсэн нь 1.2%-аар буурсан бол автотээврээр 25.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.2%-аар өссөн байна. Нийт экспортын дүнд автотээвэр 87%-ийг, төмөр зам 13%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2025 оны 4 дүгээр сард нийт 609.6 мянган тонн болж өмнөх оны 4 дүгээр сартай харьцуулахад 6.3%-аар өссөн. Харин нийт өссөн дүнгээр 2 сая тонн ачаа импортолсон нь өмнөх оны мөн үеэс 1.1%-аар буурчээ. Үүнээс төмөр замаар 1.2 сая тонн ачаа импортолсон нь 11.3%-аар буурсан бол автотээврээр 876.7 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 16.7%-аар өссөн байна. Импортын тээврийн 57%-ийг төмөр замаар, 43%-ийг автотээврээр тээсэн байна.

Зураг 3. Нийт импорт




## 1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР


Бүх төрлийн тээврээр 2025 оны 4 дүгээр сард 14.1 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны 4 дүгээр сартай харьцуулахад 0.6%-аар буурсан. 2025 оны өссөн дүнгээр буюу эхний 4 сард 51.7 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 5.5%-аар өссөн үзүүлэлттэй байна.

- Автотээврээр 2025 оны 4 дүгээр сард 13.8 сая зорчигч зорчсон нь өмнөх оны 4 дүгээр сараас 0.6%-аар буурсан байна. Харин өссөн дүнгээр нийт 50.5 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 5.6%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 49.8 сая зорчигч (+5.7%), орон нутагт 503.7 мянган зорчигч (+7.2%), олон улсад 167.6 мянган зорчигч (-19.5%) зорчжээ. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- Төмөр замаар 2025 оны 4 дүгээр сард нийт 144.9 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны 4 дүгээр сартай харьцуулахад 12.3%-аар буурсан. Нийт өссөн дүнгээр 544.1 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 9.4%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 9.9 мянган зорчигч зорчсон нь 31.2%-аар өссөн бол харин орон нутагт 534.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 9.9%-аар буурсан байна
- Агаарын тээврээр 2025 оны 4 дүгээр сард нийт 157.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны 4 дүгээр сартай харьцуулахад 13.5%-аар өссөн. Нийт өссөн дүнгээр 636.6 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 15.6%-аар өссөн бол үүнээс олон улсад 503.6 мянган зорчигч зорчсон нь 20%-аар, орон нутагт 132.9 мянган зорчигч зорчсон нь 1.8%-аар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн




Зураг 5. Олон улсын зорчигч



2025 оны эхний 4 сард олон улсад нийт 681.1 мянган зорчигч (+7.1%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 503.6 мянган зорчигч (+20%), автотээврээр 167.6 мянган зорчигч (-19.5%), төмөр замаар 9.9 мянган зорчигч (+31.2%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 74%, автотээвэр 25%, төмөр зам 1%-ийг эзэлж байна. /Зураг 5/

2025 оны эхний 4 сард орон нутагт нийт 1.2 сая зорчигч (-1.9%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 503.7 мянган зорчигч (+7.2%), төмөр замаар 534.3 мянган зорчигч (-9.9%), агаарын тээврээр 132.9 мянган зорчигч (+1.8%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 11%, автотээвэр 44%, төмөр зам 45%-ийг эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутагт зорчигч



## БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР

2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА<sup>3</sup>

2025 оны өссөн дүнгээр авто замаар нийт 26.5 сая тонн ачаа тээвэрлэснээс 25.7 сая тонн ачаа экспортолсон байна.


Хүснэгт 2

| Үзүүлэлт         | Хэмжих нэгж | 2024 он         |                 | 2025 он         |                 | Өсөлт бууралтын % /өссөн дүн/ |
|------------------|-------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|-------------------------------|
|                  |             | 4 дүгээр сар    | Өссөн дүн       | 4 дүгээр сар    | Өссөн дүн       |                               |
| <b>Нийт ачаа</b> | <b>тонн</b> | 7,219,479.5     | 25,165,165.8    | 7,828,624.8     | 26,549,284.8    | 5.5%                          |
| Импорт           | тонн        | 268,520.8       | 750,963.1       | 329,960.8       | 876,699.8       | 16.7%                         |
| Экспорт          | тонн        | 6,950,958.7     | 24,414,202.7    | 7,498,664.0     | 25,672,585.0    | 5.2%                          |
| Ачаа эргэлт      | тн.км       | 1,084,111,445.3 | 3,993,415,928.4 | 1,090,949,318.0 | 4,060,066,482.0 | 1.7%                          |

2025 оны 4 дүгээр сард автотээврээр 7.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 4 дүгээр сартай харьцуулахад 8.4%-аар өссөн байна. Үүнээс экспортод 7.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 7.9%-аар, импортоор 329.9 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 4 дүгээр сараас 22.9%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин ачаа эргэлт 4 дүгээр сард 1.1 тэрбум тонн км болсон нь өмнөх оны 4 дүгээр сараас 0.6%-аар өссөн байна.

Сар бүр тээвэрлэсэн нийт ачааны хэмжээг зураг 7-д харуулав.


Зураг 7 . Автотээврээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар



Эхний 4 сарын байдлаар автотээврээр нийт 26.5 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 5.5%-аар, экспортын ачаа 25.7 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 5.2%-аар, импортын ачаа 876.7 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 16.7%-аар тус тус өссөн байна. Ачаа эргэлт 4.1 тэрбум тонн км болж өмнөх оны мөн үеэс 1.7%-аар өссөн байна.

2025 оны өссөн дүнгээр нийт ачаа тээврийн 25.7 сая тонн буюу 97%-ийг экспортын ачаа, 876.7 мянган тонн буюу 3%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд Гашуунсухайт боомтоор экспортын ачааны 49%-ийг нэвтрүүлсэн байна. Харин импортын ачааны 75%-ийг Замын-Үүд боомтоор оруулж ирсэн ачаа эзэлж байна. /Зураг 8/

Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь




<sup>3</sup> "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын статистикийн мэдээ

## 2.1.1. АВТОТЭЭВРИЙН ЭКСПОРТЫН АЧАА, БООМТУУДААР

Хүснэгт 3

| №  | Үзүүлэлт                | Хэмжих нэгж | 2024 он      |              | 2025 он      |              | Өсөлт бууралтын % /өссөн дүн/ |
|----|-------------------------|-------------|--------------|--------------|--------------|--------------|-------------------------------|
|    |                         |             | 4 дүгээр сар | Өссөн дүн    | 4 дүгээр сар | Өссөн дүн    |                               |
| 1  | <b>Нийт ачаа тээвэр</b> | тонн        | 7,219,479.5  | 25,165,165.8 | 7,828,624.8  | 26,549,284.8 | 5.5%                          |
| 2  | Экспорт-боомтуудаар     | тонн        | 6,950,958.7  | 24,414,202.7 | 7,498,664.0  | 25,672,585.0 | 5.2%                          |
| 3  | ОХУ-руу                 | тонн        | 2,068.4      | 14,091.4     | 19,724.0     | 33,142.0     | 135.2%                        |
| 4  | Алтанбулаг              | тонн        | 2,068.4      | 14,091.4     | 19,724.0     | 33,142.0     | 135.2%                        |
| 5  | Боршоо                  | тонн        | 0.0          | 0.0          | 0.0          | 0.0          | -                             |
| 6  | Цагаан нуур             | тонн        | 0.0          | 0.0          | 0.0          | 0.0          | -                             |
| 7  | БНХАУ-руу               | тонн        | 6,948,890.3  | 24,400,111.3 | 7,478,940.0  | 25,639,443.0 | 5.1%                          |
| 8  | Бичигт                  | тонн        | 191,882.0    | 670,445.0    | 442,948.0    | 2,216,545.0  | 230.6%                        |
| 9  | Баянхошуу               | тонн        | 42,457.0     | 169,106.6    | 29,035.0     | 138,073.0    | -18.4%                        |
| 10 | Бургастай               | тонн        | 14,356.0     | 154,102.0    | 0.0          | 29,742.0     | -80.7%                        |
| 11 | Булган                  | тонн        | 297,691.0    | 972,246.0    | 273,549.0    | 959,081.0    | -1.4%                         |
| 12 | Гашуунсухайт            | тонн        | 3,300,875.2  | 12,866,142.4 | 3,119,871.0  | 12,547,156.0 | -2.5%                         |
| 13 | Замын-Үүд               | тонн        | 72,204.0     | 291,736.0    | 37,192.0     | 197,392.0    | -32.3%                        |
| 14 | Ханги                   | тонн        | 674,030.1    | 2,440,541.4  | 476,722.0    | 1,764,788.0  | -27.7%                        |
| 15 | Хавирга                 | тонн        | 0.0          | 9,452.9      | 1,522.0      | 31,219.0     | 230.3%                        |
| 16 | Шивээ хүрэн             | тонн        | 2,355,395.0  | 6,826,339.0  | 3,098,101.0  | 7,755,447.0  | 13.6%                         |
| 17 | Сүмбэр                  | тонн        | 0.0          | 0.0          | 0.0          | 0.0          | -                             |

Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн, боомтоор



ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтоор 2025 оны 4 дүгээр сард 3.4 мянган тонн ачаа, харин эхний 4 сарын байдлаар 19.7 мянган тонн ачаа гарсан нь өмнөх оны мөн үеэс 9 дахин өссөн байна.

БНХАУ-тай хиллэдэг боомтуудаар 4 дүгээр сард 7.5 сая тонн ачаа, харин өссөн дүнгээр 25.6 сая тонн ачаа гарсан нь 5.1%-аар өссөн байна. Үүнээс хамгийн их ачааг Гашуунсухайт боомтоор нэвтрүүлсэн бөгөөд 12.5 сая тонн (-2.5%) ачаа тээвэрлэсэн нь нийт экспортын 49%-ийг дангаараа бүрдүүлж байна. Шивээхүрэн боомтоор 7.8 сая тонн (+13.6%), Бичигт боомтоор 2.2 сая тонн (+230.6%), Ханги боомтоор 1.8 сая тонн (-27.7%), Булган боомтоор 972.2 мянган тонн (-1.4%), Замын-Үүд боомтоор 197.4 мянган тонн (-32.3%), Баянхошуу боомтоор 169.1 мянган тонн (-18.4%), Бургастай боомтоор 29.7 мянган тонн (-80.7%), Хавирга боомтоор 31.2 мянган тонн (+230.3%) ачаа тус тус экспортод гарсан байна. /Зураг 9/

## 2.1.2 АВТОТЭЭВРИЙН ИМПОРТЫН АЧАА, БООМТУУДААР

Хүснэгт 4

| №  | Үзүүлэлт                | Хэмжих нэгж | 2024 он      |              | 2025 он      |              | Өсөлт бууралтын % /өссөн дүн/ |
|----|-------------------------|-------------|--------------|--------------|--------------|--------------|-------------------------------|
|    |                         |             | 4 дүгээр сар | Өссөн дүн    | 4 дүгээр сар | Өссөн дүн    |                               |
| 1  | <b>Нийт ачаа тээвэр</b> | тонн        | 7,219,479.5  | 25,165,165.8 | 7,828,624.8  | 26,549,284.8 | 5.5%                          |
| 2  | Импорт –боомтуудаар     | тонн        | 268,520.8    | 750,963.1    | 329,960.8    | 876,699.8    | 16.7%                         |
| 3  | ОХУ-аас                 | тонн        | 32,400.3     | 131,306.2    | 61,281.0     | 115,559.0    | -12.0%                        |
| 4  | Алтанбулаг              | тонн        | 17,837.4     | 60,100.9     | 55,247.0     | 92,938.0     | 54.6%                         |
| 5  | Боршоо                  | тонн        | 3,323.4      | 17,757.8     | 1,614.0      | 9,695.0      | -45.4%                        |
| 6  | Цагаан нуур             | тонн        | 11,239.5     | 53,447.5     | 4,420.0      | 15,228.0     | -71.5%                        |
| 7  | БНХАУ-аас               | тонн        | 236,120.5    | 619,656.9    | 268,679.8    | 761,140.8    | 22.8%                         |
| 8  | Бичигт                  | тонн        | 654.0        | 2,247.0      | 0.0          | 0.0          | -100.0%                       |
| 9  | Баянхошуу               | тонн        | 38.0         | 38.0         | 9.8          | 9.8          | -74.2%                        |
| 10 | Бургастай               | тонн        | 84.0         | 84.0         | 0.0          | 0.0          | -100.0%                       |
| 11 | Булган                  | тонн        | 0.0          | 0.0          | 0.0          | 0.0          | -                             |
| 12 | Гашуунсухайт            | тонн        | 25,880.0     | 47,440.0     | 35,120.0     | 78,080.0     | 64.6%                         |
| 13 | Замын-Үүд               | тонн        | 194,088.0    | 528,205.5    | 223,742.0    | 654,184.0    | 23.9%                         |
| 14 | Ханги                   | тонн        | 425.0        | 3,925.0      | 1,480.0      | 3,625.0      | -7.6%                         |
| 15 | Хавирга                 | тонн        | 3,871.5      | 8,237.4      | 1,328.0      | 4,562.0      | -44.6%                        |
| 16 | Шивээ хүрэн             | тонн        | 11,080.0     | 29,480.0     | 7,000.0      | 20,680.0     | -29.9%                        |

Автотээврээр 2025 оны 4 дүгээр сард импортоор 329.9 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 61.3 мянган тонныг ОХУ-аас, 268.7 мянган тонн ачааг БНХАУ-аас оруулж ирсэн байна.

Харин өссөн дүнгээр импортын ачаа 876.7 мянган тонн байснаас 115.6 мянган тонныг ОХУ-аас оруулж ирсэн нь өмнөх оны мөн үеэс 12%-аар буурсан бол 761.1 мянган тонн ачааг БНХАУ-аас оруулж ирсэн нь өмнөх оны мөн үеэс 22.8%-аар өссөн байна.

Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор

2025 оны өссөн дүнгээр ОХУ-аас 115.6 мянган тонн ачаа оруулж ирснээс Алтанбулаг боомтоор 92.9 мянган тонн (+54.6%), Цагааннуур боомтоор 15.2 мянган тонн (-71.5%), Боршоо боомтоор 9.7 мянган тонн (-45.4%) ачаа тус тус орж иржээ.

БНХАУ-аас 761.1 мянган тонн ачаа оруулж ирснээс Замын-Үүд боомтоор 654.2 мянган тонн ачаа (+23.9%), Гашуунсухайт боомтоор 78.1 мянган тонн ачаа (+64.6%), Шивээхүрэн боомтоор 20.7 мянган тонн ачаа (-29.9%), Хавирга боомтоор 4.6 тонн ачаа (-44.6%), Ханги боомтоор 3.6 мянган тонн ачаа (-7.6%) оруулсан байна.

Импортын ачааны 87%-ийг БНХАУ-аас, 13%-ийг ОХУ-аас оруулж ирсэн. **Нийт импортын ачааны 75%-ийг Замын-Үүд боомтоор оруулж байна.** /Зураг 10/



■ 2025 оны эхний 4 сар    ■ 2024 оны эхний 4 сар

## 2.1.3. АВТОТЭЭВРИЙН АЧААНЫ НЭР ТӨРӨЛ


Хүснэгт 5

| Ачааны нэр төрлөөр | Хэмжих нэгж | 2024 он      |              | 2025 он      |              | Өсөлт бууралтын % /өссөн дүн/ |
|--------------------|-------------|--------------|--------------|--------------|--------------|-------------------------------|
|                    |             | 4 дүгээр сар | Өссөн дүн    | 4 дүгээр сар | Өссөн дүн    |                               |
| Нүүрс              | тонн        | 6,779,914.3  | 23,673,997.7 | 7,264,679.0  | 24,842,847.9 | 4.9%                          |
| Газрын тос         | тонн        | 42,457.4     | 169,106.6    | 29,035.5     | 138,074.0    | -18.4%                        |
| Зэсийн баяжмал     | тонн        | 80,951.3     | 296,577.0    | 134,579.5    | 436,854.3    | 47.3%                         |
| Төмрийн хүдэр      | тонн        | 26,648.2     | 198,318.5    | 16,790.0     | 71,534.5     | -63.9%                        |
| Жонш               | тонн        | 8,433.5      | 30,115.0     | 25,586.6     | 114,537.9    | 280.3%                        |
| Цайр               | тонн        | 0.0          | 2,699.0      | 0.0          | 0.0          | -100.0%                       |
| Бусад              | тонн        | 12,554.0     | 43,388.9     | 27,993.4     | 68,736.4     | 58.4%                         |

Авто замын боомтуудаар гарсан ачааг нэр төрлөөр авч үзвэл 4 дүгээр сард нүүрс 7.3 сая тонн (+7.2%), зэсийн баяжмал 134.6 мянган тонн (+66.2%), газрын тос 29 мянган тонн (-31.6%), төмрийн хүдэр 16.8 мянган тонн (-37%), жонш 25.6 мянган тонн (+203.4%), бусад ачаа 27.9 мянган тонн ачаа (+123%) гаргасан байна.


2025 оны өссөн дүнгээр нийт нүүрс 24.8 сая тонн (+4.9%), зэсийн баяжмал 436.9 мянган тонн (+47.3%), төмрийн хүдэр 71.5 мянган тонн (-63.9%), газрын тос 138.1 мянган тонн (-18.4%), жонш 114.5 мянган тонн (+280.3%), бусад 68.7 мянган тонн ачаа (+58.4%) тус тус экспортод тээвэрлэжээ. /Зураг 11/

Зураг 11. Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар



Авто замын боомтуудаар экспортод гарсан нүүрсний хэмжээг доорх графикт харуулав. 2025 оны 4 дүгээр сард 7.3 сая тонн гарсан нь өмнөх оны 4 дүгээр сараас 7.2%-аар өссөн бол өссөн дүнгээр 24.8 сая тонн нүүрс гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.9%-аар өссөн байна. /Зураг 12/

Зураг 12. Экспортын нүүрсний хэмжээ, тонн, сараар



## 2.1.4. АВТОТЭЭВРИЙН АЧАА ЭРГЭЛТ, БООМТУУДААР

Хүснэгт 6

| №  | Үзүүлэлт         | Хэмжих нэгж | 2024 он         |                 | 2025 он         |                 | Өсөлт бууралтын % / өссөн дүн/ |
|----|------------------|-------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|--------------------------------|
|    |                  |             | 4 дүгээр сар    | Өссөн дүн       | 4 дүгээр сар    | Өссөн дүн       |                                |
| 1  | Нийт ачаа эргэлт | тн.км       | 1,084,111,445.3 | 3,993,415,928.4 | 1,090,949,318.0 | 4,060,066,482.0 | 1.7%                           |
| 2  | Алтанбулаг       | тн.км       | 457,833.4       | 1,706,421.8     | 1,724,333.0     | 2,899,840.0     | 69.9%                          |
| 3  | Бичигт           | тн.км       | 15,402,880.0    | 53,815,360.0    | 35,435,840.0    | 177,323,600.0   | 229.5%                         |
| 4  | Баянхошуу        | тн.км       | 27,196,800.0    | 108,252,544.0   | 18,588,672.0    | 88,372,992.0    | -18.4%                         |
| 5  | Бургастай        | тн.км       | 1,155,200.0     | 12,334,880.0    | 0.0             | 2,379,360.0     | -80.7%                         |
| 6  | Гашуунсухайт     | тн.км       | 765,153,696.0   | 2,970,123,952.0 | 725,647,930.0   | 2,903,804,280.0 | -2.2%                          |
| 7  | Замын-Үүд        | тн.км       | 1,864,044.0     | 5,739,590.5     | 1,826,538.0     | 5,961,032.0     | 3.9%                           |
| 8  | Цагаан нуур      | тн.км       | 1,123,950.0     | 5,344,750.0     | 442,000.0       | 1,522,800.0     | -71.5%                         |
| 9  | Ханги            | тн.км       | 13,489,102.0    | 48,889,328.0    | 9,564,040.0     | 35,368,260.0    | -27.7%                         |
| 10 | Шивээ хүрэн      | тн.км       | 153,820,875.0   | 445,628,235.0   | 201,831,565.0   | 505,448,255.0   | 13.4%                          |
| 11 | Хавирга          | тн.км       | 89,044.9        | 406,877.2       | 65,550.0        | 822,963.0       | 102.3%                         |
| 12 | Булган           | тн.км       | 104,191,850.0   | 340,286,100.0   | 95,742,150.0    | 335,678,350.0   | -1.4%                          |
| 13 | Боршоо           | тн.км       | 166,170.0       | 887,890.0       | 80,700.0        | 484,750.0       | -45.4%                         |


2025 оны өссөн дүнгээр автотээврийн ачаа эргэлт нийт 4.1 тэрбум тонн км ачаа болсон нь өмнөх оны мөн үеэс 1.7%-аар өссөн байна. Үүнээс Гашуунсухайт боомтоор ачаа эргэлт хамгийн их байгаа бөгөөд 2.9 тэрбум тонн км байгаа нь нийт ачаа эргэлтийн 72%-ийг дангаар бүрдүүлж байна. Харин хамгийн их өсөлттэй байгаа боомт нь Бичигт буюу тус боомтоор 177.3 сая тонн км ачаа эргэлт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 3 дахин өссөн байна. /Хүснэгт 6/

## 2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Хүснэгт 7

| Зорчигч тээвэр                      | Хэмжих нэгж | 2024 он      |              | 2025 он      |              | Өсөлт бууралтын % / өссөн дүн/ |
|-------------------------------------|-------------|--------------|--------------|--------------|--------------|--------------------------------|
|                                     |             | 4 дүгээр сар | Өссөн дүн    | 4 дүгээр сар | Өссөн дүн    |                                |
| Нийт зорчигч                        | хүн         | 13,910,210.0 | 47,793,573.0 | 13,820,725.0 | 50,470,016.0 | 5.6%                           |
| Олон улсад                          | хүн         | 48,126.0     | 208,320.0    | 51,273.0     | 167,633.0    | -19.5%                         |
| Хот хоорондын                       | хүн         | 112,465.0    | 469,916.0    | 126,355.0    | 503,731.0    | 7.2%                           |
| Хот доторх нийтийн тээврээр зорчигч | хүн         | 13,749,619.0 | 47,115,337.0 | 13,643,097.0 | 49,797,290.0 | 5.7%                           |
| Зорчигч эргэлт                      | сая хүн.км  | 184.1        | 696.5        | 139.5        | 680.7        | -2.3%                          |

Зураг 13. Зорчигч тээвэр



Автотээврээр 2025 оны 4 дүгээр сард 13.8 сая зорчигч зорчсон нь өмнөх оны 4 дүгээр сараас 0.6%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 51.3 мянган зорчигч (+6.5%), орон нутагт 126.4 мянган зорчигч (+12.4%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 13.6 сая зорчигч (-0.8%) тус тус зорчсон байна.

Өссөн дүнгээр нийт 50.5 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 5.6%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 49.8 сая зорчигч (+5.7%), орон нутагт 503.7 мянган зорчигч (+7.2%), олон улсад 167.6 мянган зорчигч (-19.5%) зорчжээ.

Автотээврийн зорчигчийн 98.1%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.4%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.5%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 13/

# Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл – 2025 оны 4 дүгээр сар

Хүснэгт 8

| №        | Аймгийн нэр | Сум дүүргийн нэр  | Тээвэрлэлтийн зай | Тээврийн хэрэгслийн төрөл | Өссөн дүнгээр   |       |               |              |        | Зорчигч эргэлт /хүн+км/ |
|----------|-------------|-------------------|-------------------|---------------------------|-----------------|-------|---------------|--------------|--------|-------------------------|
|          |             |                   |                   |                           | Суудал ашиглалт | Рейс  | Зорчигч       |              |        |                         |
|          |             |                   |                   |                           |                 |       | УБ-аас гарсан | ОН-аас ирсэн | Бүгд   |                         |
| 1        | Архангай    | Цэцэрлэг          | 560               | том оврын                 | 50.3            | 10    | 399           | 304          | 776    | 434560                  |
|          |             | Эрдэнэбулган      | 498               | том оврын                 | 60.5            | 279   | 10596         | 9599         | 20706  | 10311588                |
|          |             | Тариат            | 647               | том оврын                 | 20.5            | 13    | 187           | 134          | 357    | 230979                  |
|          |             | Жаргалант         | 571               | том оврын                 | 68.2            | 12.5  | 515           | 485          | 1009   | 576139                  |
|          |             | Эрдэнэмандал      | 511               | том оврын                 | 45.1            | 15.5  | 446           | 258          | 834    | 426174                  |
| 2        | Баян-Өлгий  | Өлгий-сум         | 1709              | том оврын                 | 71.2            | 175   | 5699          | 9006         | 11925  | 20379825                |
| 3        | Баянхонгор  | Баянхонгор        | 640               | том оврын                 | 78.1            | 341.5 | 15008         | 16112        | 29847  | 19102080                |
| 4        | Булган      | Булган            | 438               | том оврын                 | 58              | 90.5  | 3001          | 3219         | 5965   | 2612670                 |
| 5        | Говь-Алтай  | Есөнбулаг         | 1037              | том оврын                 | 74.7            | 195.5 | 8323          | 8681         | 16408  | 17015096                |
